



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 2 (575)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- Хэлэлцээр соёрхон батлах тухай
- Санхүүгийн протокол, зээлийн гэрээ соёрхон батлах тухай

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- Төрийн албаны зөвлөлийн дарга, орон тооны гишүүдийг томилох тухай
- Олон нийтийн радио, Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- Хөрөнгө оруулалтын гэрээний тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДСЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны нэгдүгээр сарын 13

№2 (575)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

11.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	17
12.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	18
13.	Санхүүгийн протокол, зээлийн гэрээ соёрхон батлах тухай	18
14.	Санхүүгийн протокол, зээлийн гэрээ соёрхон батлах тухай	18

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

15.	Төрийн албаны зөвлөлийн дарга, орон тооны гишүүдийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 46	18
16.	Төрийн албаны зөвлөлийн дарга, орон тооны гишүүдийг томилох тухай	Дугаар 47	19
17.	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай	Дугаар 48	19
18.	Байнгын хорооны бүрэлдэхүүнд веерчлэлт оруулах тухай	Дугаар 49	19
19.	Дэд хорооны бүрэлдэхүүнд веерчлэлт оруулах тухай	Дугаар 50	20

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

20.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 383	20
-----	--	------------	----

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

21.	Журам батлах тухай	Дугаар 49	25
22.	Төрийн болон орон нутгийн емчийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 50	29
23.	Хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Дугаар 51	30
24.	Журам батлах тухай	Дугаар 58	31
25.	Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай	Дугаар 64	33

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХСН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Үзүүлийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн, ороонд байгуулсан "Уул уурхайн салбарын институцийн" бэхжүүлэх техникийн туслацааны

тесэл"-ийн санхүүжилтийн хэлэлцээрийг Засгийн газрын оргэн мэдүүлснээр соёрхон баталсугтай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 он №2 (575)

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан "Хууль зүйн салбарын үйлчилгээг боловсронгуй болгох тесел"-ийн санхүүжилтийн хэлэлцээрийг

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮГИЙН ПРОТОКОЛ, ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улаанбаатар хотын зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮГИЙН ПРОТОКОЛ, ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төслийн талаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, зээлийн гэрээг

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

Төрийн албаны зөвлөлийн дарга,  
орон тооны гишүүдийг үүрэгт ажлаас  
чөлөөлөх тухай

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5, 34.7 дахь хэсэгт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Жамбын Норовсамбуу Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Багаажавын Өнбөлзэт, Намжилдоогийн Чадраабал нарыг орон

тооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хотТөрийн албаны зөвлөлийн дарга,  
орон тооны гишүүндийг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4, 34.5, 34.6, 34.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн дараар Дорждамбын Зүмбэрэлхамыг, орон тооны

тишүүнээр Дашбалын Батбаяр, БагаажавынӨнөбаатар нарыг тус тус томилсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хотОлон нийтийн радио, телевизийн  
Үндэсний зөвлөлийн гишүүнээс  
чөлөөлох, гишүүнээр томилох тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8, 21.10, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс Раднаагийн Бурмаа, Лувансурэнгийн Дамдинсурэн, Цэдэндоржийн Дашидандов, Журмэдийн Занаа, Найдансурэнгийн Золжаргал, Ганхуутийн Пүрэвбат, Раднаагийн Хадбаатар нарыг тус тус чөлөөлсүгтэй.

2. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Баасанжавын Ганболд, Дамбын Гантемер, Цэрэнпилийн Гомбосурэн, Чойжилжавын Дамбажав, Цэрэнчимэдийн Зоригтбаатар, Сүрэнгийн Цэрэндорж нарыг тус тус томилсугай.

3. Энэ тогтоолыг 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хотБайнгын хорооны бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь МАХН-ын булзг, Ардчилсан намын булгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Энэбишийн Лэнх-Очирыг Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн Ламбааг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №2 (575)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

### Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Ламжавын Гүндалай Ес зүйн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Энэбийшийн Менх-Очирыг Хүний эрхийн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн Ламбааг Мянганы хөгжлийн зорилтууд болон

ядуулрыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан одреес нь буюу 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхэнд дагаж мэрдсүгэй.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 383

Улаанбаатар  
хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, хөдөө аж ахуй, шуудан холбоо, хэвлэл мэдээлэл, батлан хамгаалах, онцгой байдал, усны аж ахуйн салбар, тер

захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Гончигийн Балдандорж - Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч "МОНЦАМЭ" агентлагийн Ахмадын хорооны дарга

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Баттулгын Бат-Эрдэнэ - Нийслэлийн Сүхбаатар дуургийн Засаг даргын Тамгын газрын дарга
2. Хасбазарын Бэхбат - Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
3. Товчингийн Дашээвгэ "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" ТББ-ын гишүүн, худалдаа үйлчилгээний "Хангайн буянт" ХК-ийн захирал
4. Жанцангийн Довдон - Говь-Алтай аймгийн усны аж ахуйн "Ус-Алтай" ХК-ийн жолооч
5. Норовын Доржсүрэн - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хангамжийн мэргэжилтэн
6. Жанчиадоржийн Помбо - Гадаад харилцааны яамны зөвлөх
7. Шонхорын Мөнхбат - Төв аймгийн Эрдэнэсант сумын дунд сургуулийн зөвлөх багш
8. Сүхрагчаагийн Мөнхтер - Нийслэлийн Сүхбаатар дуургийн Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн хэлтсийн дарга
9. Довчингийн Мягмар - Стратегийн судалгааны хүрээндэгийн захирал
10. Жамъяндоржийн Нэргүй - УИХ-ын Тамгын газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга
11. Лувсанзундуйн Ням - Биеийн тамир, спортын улсын хорооны Эрдэм шинжилгээ, сургалтын төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
12. Баатарын Одсурэн - СУИС-ийн хөгжмийн онолын тэнхимийн багш
13. Луузандийн Элзийсүрэн - Дархан-Уул аймгийн "Дархан-Өлзий" авто сургуулийн захирал
14. Ширчингийн Содном - МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн захирал
15. Артхүүгийн Сосорбурам - Завхан аймгийн "Баялаг" ХК-ийн хүнсний технологич
16. Дарьсүрэнгийн Сүхбаатар - Нуудлийн соёлт иргэншилгийг судлах олон улсын нийгэмлэгийн ерөнхийлөгч
17. Чүлтэмийн Цэрэнжав - Дархан-Уул аймгийн "Энх-Ачтан" хүүхдийн эмнэлгийн змч
18. Норилын Чагнаа - Усны институтийн зөвлөх инженер
19. Даваагийн Энхээ - УБТЗ-ын "Замчин" спорт клубийн мэргжилтэн

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Дүүрэнбатын Алтангэрэл - Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулагч
2. Дэмбэрэлийн Алтанхуу - Дархан-Уул зиймийн Дархан сумын иргэн, ахмад багш
3. Дагважанцангийн Алтанцэцэг - Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч
4. Чулууны Алтанцэцэг - Сангийн яамны Төрийн сангийн алхах мэргжилтэн
5. Дорлигжавын Баасан - "Номыг тэтгэгч сүм" шашины байгууллагын тэргүүн
6. Гомбосүрэнгийн Баатар - Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн хуулийн зөвлөх
7. Билалын Бабахан - Ховд аймгийн Бүянт сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч
8. Дамдингийн Бадарч - Хөгжим бүжгийн коллежийн дэд захирал
9. Цэндийн Бадрах - Усны хэрэг эрхлэх газрын дарга
10. Цагаанхүүгийн Балжинням - Ус аймгийн Зүүнхангай сумын малчин
11. Чулууны Батбаатар - Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын алхах мэргжилтэн
12. Цэвээний Батдэмбэрэл - Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэний бүртгэл, мэдээллийн тасгийн дарга
13. Найдангийн Батмөнх - "Монголын анчдын нийгэмлэг" төрийн бус байгууллагын мэргжилтэн
14. Цагаачийн Бат-Өлзий - ШУТИС-ийн харьцаа Дулааны төвийн экологийн хүрээлэнгийн эрдэмтн нарийн бичгийн дарга
15. Дарамрагчаагийн Батсүх - Ашигт мартмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын алхах мэргжилтэн
16. Батвахуупийн Баянжаргал - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын халтсийн дарга
17. Магваны Болд - Хас банкны ервижийн захирал
18. Лувсандамдингийн Бямбасүрэн - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн алхах мэргжилтэн
19. Лувсангийн Ванчиг - Завхан аймгийн Усны аж ахуйн "Тэсийн бурд" ХХК-ийн жолооч
20. Балжирын Ваня - Геоэкологийн хүрээлэнгийн төсөөчин
21. Дамдинсүрэнгийн Ганзориг - Төв аймгийн "Төв-Ус" ХК-ийн захирал
22. Дагвацэрэнгийн Гомбо - "Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлийн хороо" төрийн бус байгууллагын дарга
23. Сундуйн Гонгон - Увс аймгийн Улаангом сумын ёндер настан, ахмад багш
24. Агаандарамын Гүрбадам - ЭМШУИС-ийн оюутны албаны декан
25. Дашийн Дагиймаа - Хадгаламж банкны тооцооны 14 дүгээр төвийн захирал
26. Жамъяны Далай - Нийслэлийн усны аж ахуйн "Престиж инженеринг" ХХК-ийн еренхий захирал
27. Пунцагхоролын Дамбий - Орхон аймгийн усны аж ахуйн "Бүрхаш" бүрэн бус нөхчөлөлийн бригадын дарга
28. Лувсанбалдангийн Дашээвэг - Төв аймгийн Батсүмбэр сумын ёндер настан, худалдааны байгууллагын ахмад ажилтан
29. Гармажийн Долгорсүрэн - Усны хэрэг эрхлэх газрын "Монгол орны усны нэгжсэн менежментийн бахжуулэх нь" төслийн менежер
30. Нямсүрэнгийн Дэлгэг - Төв аймгийн "Тунгалаг-Ус" ХХК-ийн захирал
31. Дэлэгдоржийн Жадамбаа - Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдаа Египет Улсад суугаа Онц бөгөөд Бурэн эрхт Элчин сайдын яамны аж ахуйн эрхлэгч-жолооч
32. Лунтэнгийн Жанчивдорж - Геоэкологийн хүрээлэнгийн усны неец, ус ашиглалтын салбарын эрхлэгч
33. Аюурзанын Жаргалтайхан - Өмнөговь аймгийн усны аж ахуйн "Түний ус" ХХК-ийн захирал
34. Цамбын Жигдэн - Радио, телевизийн сүлжээний газрын еренхий нягтлан бодогч
35. Чонойн Куланда - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд
36. Пүрэвсүрэнгийн Лхагвасүрэн - Орхон аймгийн Орон нутгийн емчийн албаны дарга
37. Лантуугийн Магсаржав - Дорноговь аймгийн "Ускуулаг" ХХК-ийн жолооч
38. Ядамын Менхжаргал - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны иргэн, хувираа хөдөлмөр эрхлэгч
39. Тумэнгийн Намсрайжав - Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хорооны ёндер настан, ахмад кино найруулагч
40. Долгорын Натар - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Сонгинохайрхан дүүргэдэх мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын алхах байцаагч
41. Гомбын Нээв - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны ёндер настан, ахмад багш
42. Балжингийн Нямаа - Ахмад дипломатч
43. Даваагийн Нямдаваа - Булган аймгийн усны аж ахуйн "Булган - Үндэрга" ХК-ийн ермийн зөвлөх мастер



44. Цогтын Нямсүрэн - Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын яамны зөвлөх
45. Дарьбазарын Очиржанцан - Завхан аймгийн усны аж ахуйн "Уст хайрхан" хоршооны бригадын дарга
46. Дарьхуугийн Оюун - Сангийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
47. Цээзнийн Оюун - Увс аймгийн усны аж ахуйн "Ус-Эрдэнэ" ХХК-ийн захирал
48. Пүрэвсүрэнгийн Оюунбилэг - Төв аймгийн Угаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын дарга
49. Хунгаагийн Оюундэлгэр - Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
50. Гончигсүрэнгийн Оюунчимэг - ГХЯ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн
51. Далхжавын Оюунчимэг - Улсын Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсролын хяналтын улсын албаны дарга
52. Дамбын Оюунчимэг - Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн байцаагч
53. Дандарын Оюунчимэг - Үндэсний статистикийн газрын Статистикийн төлөвлөлт, зохицуулалтын газрын хүн ам, нийгмийн статистикийн хэлтсийн дарга
54. Жижидийн Пүрэвжав - "Монголын цаначдын холбоо" төрийн бус байгууллагын Ахмадын зөвлөлийн дарга
55. Мангалын Пүрэвдорж - Завхан аймгийн усны аж ахуйн "Тэсийн бурд" ХХК-ийн жолооч, авто механик
56. Ламдангийн Рагчаадорж - Увс аймгийн "Барилгын инженерүүд" ХХК-ийн захирал
57. Пагмын Санжаа - Дорноговь аймгийн усны аж ахуйн "Усжуулагч" ХХК-ийн засварын цехийн мастер
58. Мижидийн Содномжамц - Говь-Алтай аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад
59. Долгорын Сумьяа - Дархан-Уул аймгийн 11 жилийн 15 дугаар сургуулийн захирал
60. Төрбадрахын Темэрбаатар - Завхан аймгийн Дөрвөлжин сумын малчин
61. Шаравдоржийн Түвшндорж Монголын Ардчилсан Холбооны дээд дарга
62. Цэрэнгийн Түдэв - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Энергостар" ХХК-ийн нягтлан бодогч
63. Отгоны Түмэнжаргал - Дорноговь аймгийн усны аж ахуйн "Усжуулагч" ХХК-ийн жолооч
64. Санжийн Ургамал - Увс аймгийн "Худэнгийн уурхай" ХХК-ийн захирал
65. Дашизвэгийн Халтмай - Сүхбаатар аймгийн дээр настан, тэр захиргааны байгууллагын ахмад ажилтан
66. Жанжаахуунийн Халтар - Нийслэлийн барилгын Монгол-Хятадын хамтарсан "Зуншин" ХХК-ийн гүйцэтгэх захирал
67. Нацагийн Хишгээ - Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ҮЗ-ийн хорооны дарга
68. Жамъяндоржийн Хишигдорж - Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын орлогч, Төрийн сангийн төлөөвлөгч
69. Цэрэнгийн Хорлоо - Дорнод аймгийн "Худалдаа, эд хэрэглэгчдийн холбоо"-ны гишүүн, худалдагч
70. Жутааны Хумбаа - Увс аймгийн Малчин сумын ондөр настан
71. Сономцэвээний Хүрэлбаатар - "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" төрийн бус байгууллагын гишүүн, чөлөөт уран бүтээлч
72. Насангийн Цогтсайхан - Улсын Их Хурлын Тамгын газрын ахлах зөвлөх
73. Хишигдоогийн Цэвэлгончиг - УБТЗ-ын дуу бужгийн чуулгын ахмад хөгжимчин
74. Дашизвэгийн Цэрмаа - Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн бага ангийн багш
75. Лхасурэнгийн Цэрмаа - Клиникийн дүгээр амаржих газрын эх баригч-бага эмч
76. Санжаагийн Цэрэнтил - Геоэкологийн хүрээлэнгийн зураг төслийн зөвлөх инженер
77. Базын Чулуунбаатар - Нийслэл дэх худалдаа, үйлчилгээний "Моннис интернэшнл" ХХК-ийн ерөнхий захирал
78. Чулхэрэмийн Шархүү - Дундговь аймгийн "Чандмань-Дундговь" ХК-ийн бригадын засварчин, жолоч
79. Пүрэвжавын Эрдэнэбат - Завхан аймгийн усны аж ахуйн "Уст хайрхан" хоршооны гидрогеологи инженер
80. Пүрэвсүрэнгийн Энхбаяр - Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын яамны аж ахуй хариуцсан зөвлөх
81. Даанайн Энхтуяа - Увс аймгийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн албаны дарга
82. Чойжилын Ядам - Дархан-Уул аймгийн усны аж ахуйн "Дархан-Ус суваг" ХК-ийн Ахмадын зөвлөлийн дарга



## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Ендонгийн Амарбаясгалан - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад
2. Доржгооогийн Рэнчиндорж - Архангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сүхбаатарын Амарсанаа - Шүүх эрх мэддлийн шинэтгэлийн хөтөлбөрийн олон нийтийн боловсрол эрхэлсэн зохицуулагч
2. Цэрэнчимээдийн Амарсанаа - Телевизийн дамжуулах станцын антенны техник
3. Чойжилсүрэнгийн Амгаабазар - Нийслэл дэх усны аж ахуйн "Престиж инженеринг" ХХК-ийн угсралтын инженер
4. Лувсангийн Баасгай - Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төвлөлгчдийн Хурлын дарга
5. Гаанжуурын Баатархүү - Монгол шуудан" ХХК-ийн хүргэгч-жлооч
6. Доохуугийн Бадарч - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын татварын улсын байцаагч
7. Гурдаагын Батжаргал - Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний албаны дарга
8. Равдангийн Баттогтох - Дархан-Уул аймгийн усны аж ахуйн "Дархан-Ус суваг" ХК-ийн тракторчин
9. Бэгээний Батхуяг - ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн дэд профессор
10. Бадрахын Бат-Эрдэнэ - Нийслэл дэх эрчим хүчиний "Хасу-Эрчим" ХХК-ийн захирал
11. Цэвэлмаагийн Бодл - Нийслэл дэх үйлдвэр, худалдааны "Ханын материал" ХК-ийн үйлдвэрийн дарга
12. Даваадоржийн Булган - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нийгмийн ажилтан
13. Довдонгийн Булган - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, тохижилт үйлчилгээний хэлтсийн дарга
14. Дамдингийн Гаваа - Завхан аймгийн Түдэвтэй сумын холбооны салбарын ахлагч
15. Далхагийн Галбадрах - БХЯ-ны харьяа Дүрэмт хувцасны оёдлын "Бертэ" ТӨҮГ-ын оёдолчин
16. Жамцын Ганболд - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эргэлтийн ус хангамжийн хэсгийн машинч
17. Сүхбатын Ганзориг - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга
18. Оттоны Гантулга - Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
19. Төржаргалын Гончигсумлаа - Нийслэлийн "Соёл" дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч
20. Лувсаннямаагийн Гүмэнжав - ГХЯ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын ахлах мэргжилтэн
21. Очирбатын Дагвадорж - Нийслэл дэх усны аж ахуйн "Престиж инженеринг" ХХК-ийн ахлах инженер
22. Нолсоны Долгорсүрэн - Клиникийн 1 дүгээр амаржих газрын сувилагч
23. Пүрээгийн Дэлгэрсайхан - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын бодлого төвлөвлөлт хариуцсан менежер
24. Чойжилсүрэнгийн Жавзан - Геоэкологийн хүрээлэнгийн экологийн судалгааны салбарын эрхлэгч
25. Жамъяны Жавзандолгор - Хэнтий аймгийн Баянхутаг сумын 1 дүгээр багийн малчин
26. Мэдэрийн Жаргал - Увс аймгийн Улаантом сумын "Дун цагаан" ерхийн эмнэлгийн их эмч
27. Галсанбалдангийн Занданхүү - Нийслэлийн "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн дэд захирал
28. Нацадоржийн Зандраасурэн - Нийслэл дэх хувийн хөвшлийн "Таны төвлө бид" эмнэлгийн мэс заслын сувилагч
29. Чойлильн Иванов - Орхон аймаг дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч
30. Санокмявын Лида - Сүхбаатар аймгийн усны аж ахуйн "Баруун-Урт ус" ХК-ийн дэд захирал
31. Доржхуугийн Лоюндсүрэн - Архангай аймгийн Ихтамир сумын мал эмнэлгийн "Дашбанзад" хоршооны эзэн
32. Дуламсүрэнгийн Лхагва - Зэвсэгт хүчиний Клиникийн төв госпиталийн мэс заслын тасгийн бооптын сувилагч
33. Самдангийн Лхагвадорж - Нийслэлийн усны аж ахуйн "Престиж инженеринг" ХХК-ийн зургийн инженер
34. Долгорын Махвал - Завхан аймгийн Тосонцэнгэл сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
35. Цэрэндашийн Монхор - Завхан аймгийн усны аж ахуйн "Тэсийн бурд" ХХК-ийн бригадын дарга
36. Дарьзавын Моонон - Сүхбаатар аймгийн "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн аж ахуйн менежер



37. Дондовын Мэндсайхан - Нийслэлийн Соёл урлагийн газрын уран сайхны удирдагч
38. Цэдэн-Иший Наваансурэн - Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Ховд аймаг дахь улсын нөөцийн салбарын нягтлан бодогч, дээд даслэгч
39. Гарамжавын Намсрай - Сэлэнгэй аймгийн "Сэлэнгэ АЗЗА" ХК-ийн замчин-жолооч
40. Цэвээний Нарангэрэл - Завхан аймгийн усны аж ахуйн "Тэсийн бүрд" ХХК-ийн гагнуурчин
41. Охинжавын Нарандуулам - Дархан-Уул аймгийн барилга угсралтын "Хашцамхаг" ХХК-ийн инженер
42. Жүгдэрийн Наранцацалт - Дархан-Уул аймгийн "Оюуны ирээдүй" цогцолбор сургуулийн багш
43. Санжжавын Насанбат - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Тээврийн үйлчилгээний төвийн алхах мэргжилтэн
44. Довдонгийн Нураман - Сэлэнгэй аймгийн "Сэлэнгэ АЗЗА" ХК-ийн салбарын эрхлэгч
45. Гармаагийн Нэргүй - Нийслэлийн нийтийн тээврийн "Автобус-1" ХК-ийн жолооч
46. Гомбосуронгийн Нэргүй - Зэвсэгт хүчиний 032 дугаар аянгийн тооцооны нягтлан бодогч
47. Санжийн Нямдорж - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ус суулагч ашиглалтын "Үндарга" ХХК-ийн захирал
48. Дарамбазарын Нямсүрэн - СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн ардын хөгжмийн тэнхмийн эрхлэгч
49. Сэнгийн Оргодол - Нийслэлийн Гачуурт тосгоны хүн эмзилгийн бага эмч
50. Гаваагийн Окоун-“Монголын барилгачдын холбоо” териин бус байгууллагын гүйцэтгэх захирал
51. Анандын Оюунцэцэг - Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих “Эрхэм чанар” териин бус байгууллагын тэргүүн
52. Аюурзанын Оюунчимэг - Клиникийн 1 дүгээр амаржих газрын эм найруулагч
53. Бадарчийн Оюунчимэг - Клиникийн 1 дүгээр амаржих газрын эх баригч
54. Даасурэнгийн Өлзийбат - СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн алхах тогооч
55. Лувсанжамцын Пүнцаг - Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Орхон аймаг дахь улсын нөөцийн салбарын харуул
56. Бадамын Пүрэвцэвээн - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын хүн эмзилгийн дүн бүртэгч бага эмч
57. Шагдарын Солонго - Төв аймгийн Угаалцайдам сумын Засаг даргын орлогч
58. Дэмидийн Сүрэн - Сэлэнгэ аймгийн Орхон сумын Засаг даргын Тамгын газрын хөгжлийн халамж үйлчилгээний байцаагч
59. Шаравын Сэлэнгэ - ГХЯ-ны Төрийн захирагаа, удирдлагын газрын дипломат шуудан-нууцын эрхлэгч
60. Дэлэгийн Төмөр-Очир - TV-9 телевизийн менежер
61. Гэндэваагийн Удвалцэцэг - Геозоологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
62. Цэвээний Хандсүрэн - Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Төв аймгийн Цээл сум дахь улсын нөөцийн салбарын дарга, дээд даслэгч
63. Цэвэгжамцын Хуягбаатар - Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хэнтий аймаг дахь улсын нөөцийн салбарын дарга, шадар ахмад
64. Цэндийн Хуягбаатар - Төв аймгийн усны аж ахуйн "Түнгэлэг-Ус" ХХК-ийн инженер
65. Махбуриадын Цогзолмаа - БХ Я - ны харьяа Дүрэмт хувцасны оёдлын "Бэртэ" ТӨҮГ-ын оёдолчин
66. Сандуйжавын Цэндэжаргал - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын бригадын ахлагч
67. Цэдэвийн Цэцэгээ - Клиникийн 1 дүгээр амаржих газрын нярайн алхах сувилагч
68. Охиноогийн Цэцэгмаа - Клиникийн 1 дүгээр амаржих газрын эх баригч
69. Жавын Цээлэй - Увс аймгийн ус цаг уурын "Улаангом" өртөөний технич
70. Дашдоржийн Цээсүрэн - "Монгол шуудан" ХХК-ийн 46 дугаар салбарын ялгач
71. Нямжавын Чанрав - Завхан аймгийн усны аж ахуйн "Амь - Ус трейд" ХХК-ийн машинист
72. Цэрэнжавын Шагдарсүрэн - Нийслэл дэх усны аж ахуйн "Пrestij инженеринг" ХХК-ийн алхах инженер
73. Дагвадоржийн Энхбат - Дархан-Уул аймгийн "Залпуучууд" театрын гоцлол дуучин
74. Ядамын Энхбат - Завхан аймгийн усны аж ахуйн "Уст хайрхан" хорооноы өрмийн алхах мастер
75. Доржжандын Энхжаргал - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 5 дугаар сургуулийн бага ангийн багш
76. Жамъянгийн Энхцаг - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын хүн эмзилгийн их эмч
77. Бямбасүрэнгийн Эрдэнэ - Булган аймгийн усны аж ахуйн "Булган-Үндарга" ХК-ийн өрмийн мастер, жолооч



78. Бямбаагийн Эрдэнэцэцэг - Зэвсэгт хүчиний Барилгын цэргийн 017 дугаар ангийн тосвийн инженер

79. Самбуулийн Эрдэнэчимэг - Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн захирал

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Махсутын Амантай - Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын хэлтсийн нярав, багны засварчин, дээд түрүүч

2. Батхандын Амарсанаа - Сэлэнгэй аймгийн Онцгой байдлын хэлтсийн ажлын албаны дарга, тэргүүн ахмад

3. Дагдандоржийн Ариундалай - Онцгой байдлын өрвний газрын Холбоо мэдээллийн хэлтсийн дарга, дээд ахмад

4. Батаагийн Батсайхан - Зэвсэгт хүчиний 014 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

5. Дугарсүрэнгийн Бямбаогт-Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дээд ахмад

6. Сандагдоржийн Даваасурэн - Хөвсгөл аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

7. Басангийн Лхамжав - Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч, шадар ахмад

8. Хасын Мөнхжаргал - Онцгой байдлын ерөнхий газрын мэргжилтэн, дээд ахмад

9. Загарын Мянганбуу - Орхон аймгийн Онцгой байдлын хэлтсийн гэрээт гол унтраах 58 дугаар ангийн аврагч-жолооч, дээд түрүүч

10. Галаагийн Пүрэв - Зэвсэгт хүчиний 256 дугаар ангийн нууцын дарга, ахлах ахлагч

11. Санжавын Цэндсүрэн - Нийслэлийн Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

12. Борын Чинзориг - Зэвсэгт хүчиний 189 дүгээр ангийн холбооны жижкуур, хошууч

13. Аюуранын Энхбат - Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигтэй тэмцэх газрын мэргжилтэн, тэргүүн ахмад

14. Дандранийн Энхболд - Зэвсэгт хүчиний Барилгын цэргийн 017 дугаар ангийн барилгачин

15. Пүрэвцэрэнгийн Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчиний 186 дугаар ангийн ашиглалтын инженер, ахлах дэслэгч

## "ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР:

Чинзоригийн Баттувшин - УБТЗ-ын харьяа Сэлэнгэй аймаг дахь цэрэгжүүлсэн хамгаалах салааны харуулч

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
 хот

## Журам батлах тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ыг хавсралтын ёсоор шинчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1998 оны

2 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтооолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй бопсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД

Л.БОЛД

Засгийн газрын 2008 оны 49 дүгээр  
тогтооолын хавсралт

## ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн

цэргийн албыг дүйцүүлэн хаахад энэ журмыг дагаж мөрдөнө.

2. Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүргэг бүхий иргэн энэ журамд заасны дагуу веерийн хүснэгтээр орон нутаг



дахь батлан хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн онцгой байдлын асуудал хариуцсан чиг үүрэг бүхий алба, мэргэжлийн анги, салбар, хилийн цэрэгт туслах хүчин, хүмүүнлэгийн бусад байгууллага (цаашид "алба хаалгач байгууллага" гэнэ)-д цэргийн албыг дүйцүүлэн хааж болно.

3. Монгол Улсын иргэн (цаашид "иргэн" гэх)-ий цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацааг хуулиар зохицуулна.

4. Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаары батлан хамгаалах асуудал хариуцсан терийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар жил бурийн I улиралд багтаан аймаг, нийслэл бүрээр тогтооно.

5. Иргэнээр цэргийн албыг дүйцүүлэн хаалгах арга хэмжээг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулна.

6. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, дадлага, орон нутаг дахь батлан хамгаалах үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах дайчилгаа (цаашид "дайчилгаа" гэх), цугларалт болон хил хамгаалалтад оролцсоныг үүргээ гүйцэтгэсэн тооцно.

#### Хоёр. Дүйцүүлэх албанд иргэнийг авах

7. Иргэний дараах шалтгаанаар цэргийн дүйцүүлэх албанд элсүүлж болно:

а) сүм, хийдэд албан ёсоор шавилан суугаа;

б) шашин шүтлэг-ёс зүйн шалтгаанаар цэргийн жинхэнэ алба хаах боломжгүй болохыг цэрэг татлагын товчоо тодорхойлсон;

в) хил орчмын нутагт байнга оршин сууж хил хамгаалалтад туслах гишүүний үүргийг биелүүлдэг.

8. Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаахыг хүссэн өргөдлөө сум, хорооны Засаг даргаар уламжлан харьяалагдах цэрэг татлагын товчоонд гаргана.

#### Гурав. Цэргийн албыг дүйцүүлэн хаах

9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, онцгой байдлын асуудал хариуцсан чиг үүрэг бүхий алба, мэргэжлийн анги, салбар, хилийн хорооны удирдлага тухайн цэрэг татлагын товчооны шийдвэр, хуваарийн дагуу цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийг хүлээн авч бүртгэн, уг албыг хаалгах ажлыг зохион байгуулна.

10. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарган шийдвэрийн дагуу дараах үүрэг гүйцэтгэн:

а) орон нутаг дахь батлан хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

б) аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг (ой, хэзэрийн түймэр, усны үер, ган, зуд, цөлжилт, хүчтэй цасан болон широон шуурга, газар хөдлөлт, дэлбэрэлт, цацраг идэвхт болон хүчтэй үйлчилгээтийн хорт бодис алдагдах зэрэг)-ийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэдээрээс хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, түүнтэй тэмцэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулжүй сэргээн босгох ажиллагаанд оролцох;

в) хүн, малын гоц халдварт өвчний үед тогтоосон хорио цээрийн дэглэмийг сахиулахад дэмжлэг үзүүлэх;

г) улсын хилийн бус, зуравст улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад оролцох;

д) хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;

е) улс орны хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн босголтын ажилд зохион байгуулалтад оролцох.

11. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн тухайн сум, дүүргийн Засаг дарга, алба хаалгагч байгууллагаас дуудсан хугацаанд хувийн бэлтгэлээ ханган ирж, оногдуулсан үүргийг гүйцэтгэнэ.

12. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн алба хаах хугацаанд ба сараас доошгүй хугацаагаар дүйцүүлэх албаны оногдуулсан үүргийг биечлэн гүйцэтгэсэн байна.

13. Цэргийн штаб, иргэн болон алба хаалгагч байгууллага цэргийн албыг дүйцүүлэн хаах тухай гэрээ байгуулна.

#### Дөрөв. Дүйцүүлэх албаны сургалт

14. Цэргийн албыг дүйцүүлэн хаах шийдвэр гарсан иргэний цэргийн анхан шатны бэлтгэл болон үүрэг гүйцэтгэхдээ шаардагдах мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалтыг аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штаб, алба хаалгагч байгууллага хамтран зохион байгуулна. Дайчилгааны бэлтгэл нөөцийн 2 дугаар үүргийн бэлтгэл үүрэгтний сургалтын хотөлбөрийн дагуу цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг жилд 1 удаа, гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлагыг гүнзгийрүүлэх сургалтыг жилд 2-оос доошгүй удаа тус бүр 14 хоногийн хугацаагаар зохион байгуулж явуулна. Сургалтын хотөлбөрийн 30 хүртэл хувьд орон нутгийн онцлогийг харгалзан зохих өөрчлөлт оруулж болно.

15. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, дадлагын ном, сурах бичиг, үзүүлэн таниулах материал, гарын авлага, техник хэрэгслийн жагсаалтыг алба хаалгач байгууллага тогтоож, хангана.

16. Алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшар ажиллаж байгаад цэргийн албыг дүйцүүлэн хаасанд тооцогдсон иргэн цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад заавал хамрагдана.

17. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний цэргийн анхан шатны бэлтгэл болон үүрэг гүйцэтгэхдээ шаардагдах мэдлэг, дадлага эзэмшиүүлэх сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж болно.

#### Тав. Дүйцүүлэх алба хааж байгаа иргэний хүлээх үүрэг

18. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

а) томилгоот үүргээ биелүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх;

б) цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаанд ёөрийн ажил, амьдралыг албаны эрх ашигт нийцүүлэн зохицуулах;

в) даалгасан үүргийг шударга, хариулагатай биелүүлэх;

г) дайчилгaa зарласан болон цугларах дохио хүлээн авмагж заасан газар, тогтоосон хугацаанд хувийн бэлтгэлээ бүрэн ханган хүрэлцэн ирж, оногдуулсан үүргийг гүйцэтгэх;

д) тухайн орон нутгаас 5-аас дээш хоногоор гадагж явах тохиолдолд заавал аймаг, дүүргийн Цэргийн штаб эсхүл сумын Засаг даргын Тамгын газраас зөвшөөрөл авах;

е) сум, дүүргийн Засаг дарга, алба хаалгач байгууллагын удирдлагын шийдвэрийг биелүүлэх;

ж) оногдуулсан үүрэгтэй нь холбоотой зерчил гарсан үед энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, алба хаалгач байгууллагын удирдлагад шуурхай мэдэгдэх.

#### Зургас. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, алба хаалгач байгууллагын чиг үүрэг

19. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) Засгийн газраас тогтоосон цэргийн албыг дүйцүүлэн хааж иргэдийн тооны дээд хязгаарыг үндэслэн сум, дүүргэг алба хаах иргэний тоог батлах;

б) аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний сургалт, бусад шаардагдах зардлыг батлах;

в) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнд үүрэг гүйцэтгэхдээ шаардагдах эд материалын жагсаалтыг батлах.

20. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний нэрсийн жагсаалтыг батлах;

б) дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний сургалт, бусад шаардагдах зардлыг батлах.

21. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны талаархи саналаа батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сард багтаан гаргаж огхе;

б) цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний сургалт, алба хаахтай холбогдон гарах зардлын төслийг Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

в) Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан жагсвалт болон Цэргийн штабын саналыг тус тус үндэслэн цэргийн дүйцүүлэх албыг хаялах, халах тухай шийдвэр гаргах;

г) цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн цэргийн анхан шатны бэлтгэл сургалт зохион байгуулах;

д) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ үнэнчээр биелүүлж амжилт гаргавал тэднийг шанах, урамшуулах, дээд шатны байгууллагын шагналд тодорхойлох.

22. Сум, дүүргийн Засаг дарга дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) сумын Засаг дарга цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэний хүсэлт, үндэслэлийг нарийвчлан хянаж, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчтэй зөвшилцен саналаа аймгийн Засаг даргад хүргүүлэх;

б) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, цугларалт, дайчилгaa, едер тутмын үйлжиллагааг удирдан зохион байгуулах;

в) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;

г) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ үнэнчээр биелүүлж амжилт гаргавал тэднийг шанах, урамшуулах, дээд шатны байгууллагын шагналд тодорхойлох;

д) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ гүйцэтгэх байх үедээ тахир дутту болсон, амь насас алдсан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу холбогдох тэтгэвэр, тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлүүлэх;



е) цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаандаа хүндэтгэн үзүүхээс бусад шалтгаанаар сургалт, цугларалт, дайчилгааг тасалсан, үүрэг биелүүлэхээс татгалзсан, сахилга хариуцлага алдсан, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн иргэний уг албанаас хасах саналаа аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх (дуургийн Засаг дарга иргэний уг албанаас хасах);

ж) шаардлагатай тохиолдолд цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ гүйцэтгэх үед нь ажлын хувцас, багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авах;

з) цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаа дууссан иргэний уг албанаас халах тухай саналаа аймгийн Засаг даргад хүргүүлэх (дуургийн Засаг дарга Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан жагсаалт болон Цэргийн штабын саналыг тус тус үндэслэн цэргийн дүйцүүлэх албыг хаалгах, халах тухай шийдвэр гаргах);

и) алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар ажиллаж байгаа иргэний цэргийн албыг дүйцүүлэн хаасанд тооцуулах тухай саналаа аймгийн Засаг даргад хүргүүлэх.

23. Цэргэ татлагын товчоо дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэний өргөдлийг аймаг, дуургийн Засаг даргад уламжлах;

б) алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар ажиллаж байгаа иргэний цэргийн албыг дүйцүүлэн хаасанд тооцоух тухай саналаа аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

24. Цэргийн штаб дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) аймаг, дуургийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн цэргийн үүрэгтний үнэмлэхэд цэргийн дүйцүүлэх албандаа элсүүлсэн болон хугацаа дууссан тухай тэмдэглэл хийх;

б) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнд алба хаах хуудас олгох, алба хаасан тэмдэглэлийг хөтөх;

в) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

г) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа байдал, түүний зохион байгуулалт, үйл ажиллагаанд хянгалт тавьж, Засаг даргад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

д) цэргийн албыг дүйцүүлэн хаахтай холбогдсон буртгэл, тайлан, мэдээллийн асуудлыг эрхлэх;

е) цэргийн албыг дүйцүүлэн хаагчийн цэргийн анхан шатны балтгал болон үүрэг гүйцэтгэх мэргэжлийн анхан шатны мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалтыг алба хаалгагч байгууллагатай хамтран зохион байгуулах;

ж) цэргийн албыг дүйцүүлэн хаагчтай байгуулсан гарзанийн биелэлтийг дүгнэх.

25. Алба хаалгагч байгууллага дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) цэргийн албыг дүйцүүлэн хаахаар хуваарилагдан ирсэн иргэний хүлээн авч, байнга дагаж мөрдхөө эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулах, үүрэг гүйцэтгэх мэргэжлийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалтыг аймаг, дуургийн Цэргийн штабтай хамтран зохион байгуулах;

б) цэргийн албыг дүйцүүлэн хаагчид үүрэг гүйцэтгэх үед байр, хүнс, тусгай хувцас, хэрэгслээр хангах;

в) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ үнэнчээр биелүүлж амжилт гаргавал тэднийг шагнах, урамшуулах, шатналд тодорхойлох;

г) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний алба хаасан тухай тодорхойлолтыг аймаг, дуургийн Цэргийн штаб гаргах, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийх;

д) цэргийн албыг дүйцүүлэн хаасан иргэний уг албанаас халах тухай санал, тодорхойлолтоо аймаг, дуургийн Засаг даргад гарган өгч шийдвэрлүүлэх;

е) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн оногдуулсан үүргээ гүйцэтгэх байх үедээ тахир дутуу болсон, амь наасаа алдсан тохиолдолд хуулийн тогтоомжийн дагуу холбогдох тэтгэвэр, тэтгээмж олгуулсан саналыг эрх бүхий байгууллагад тавих;

ж) гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, сахилга хариуцлага алдсан болон бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хаах боломжийг болсон иргэний уг албанаас хасах тухай саналаа аймаг, дуургийн Засаг даргад гаргаж шийдвэрлүүлэх.

26. Аж ахуйн нэгж, байгууллага дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а) цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэний харьялах сум, дуургийн Засаг даргад уламжлах;

б) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний дуудсан хугацаанд үндсэн ажлаас нь чөөлж сургалт, цугларалт, дайчилгаанд оролцох, оногдуулсан үүргээ гүйцэтгэх нехцэл боломжоор хангах;

в) цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, дадлага, дайчилгааг, цугларалт болон хил хамгаалалтад оролцох хугацаанд түүний эрхэлж байсан ажил, албан тушаалыг нь хэвээр хадгалж, дундаж цапин хөлсийг олгох.

### Долоо. Бусад зүйл

27. Зарлан дуудсан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй,



сургалт, цугларалт, дайчилгаанаас зайлсхийсэн болон энзүү жurmыг зөрчсөн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний уг албанаас хасч, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийтгэл ногдуулна.

28. Цэргийн дүйцүүлэх албанаас хасагдсан иргэн цэргийн жинхэнэ алба хаах үүргэс чөлөөлгөхгүй.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
 хот

**Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандивын хөрөнгөөр 2004-2008 онд төрийн болон орон нутгийн өмчилэлд бий болсон хөрөнгийг буртгах, үнэлэх, санхүүгийн тайланд бүрэн тусгах ажлыг 2009 оны I улиралд багтаан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дүнг нэгтгэн Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус даалгасугай.

2. Улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын орд газруудын хилийн уртраг, ерөрөг болон тусгай зөвшөөрөл эзэмшигийг нарийвчлан тогтоож орд бүрээр нь нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг төрийн өмчийн буртгэлд тусгах асуудлыг 2009 оны I улиралд багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, зорчим хүчиний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

3. Төсвийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийг буртгах, үнэлэх, санхүүгийн тайланд тусгах, хадгалах журам болсовруулж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэхийг Оюуны өмчийн газрын дарга Н.Чинбат, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Монгол Улсын геодезийн цэг, тэмдэгтийн нарийвчилсан тооллогийн хийх зардлыг улсын төсвийн тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод, тооллогын ажлыг 2010 оны эхний хагас жилд багтаан хийж дуусган ашиглалтад, хадгалалтад, хамгаалалтад нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар)-нд, дүнг нэгтгэн Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус даалгасугай.

29. Цэргийн дүйцүүлэх албанад иргэнийн авах, уг албыг хаах, түүнээс хасах, халахтай холбогдсон зөрчил, маргааныг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээн. Засаг даргын шийдвэрийг эс зөвшөөрөл тухайн иргэн гомдлоо дээд шатны байгууллага буюу шүүхэд гаргана.

5. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөвлөгөөний газруудын эзэмшилд байгаа газар, үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын болон суугаа орны эрх зүйн орчинд нийцүүлэн баталгаажуулах, маргаантай эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд С.Батболд, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

6. Өрхийн эмнэлгийн барилга, эд хөрөнгө болон "Эмийн эргэлтийн сан"-д эзэмшиүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчилэлд буртгах, ашиглалтад нь хяналт тавьж ажиллах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дүнг 2009 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус даалгасугай.

7. Төрийн болон орон нутгийн өмчийн худаг, услалтын систем, зам, гүүр болон радио, төлөвийн, үүрэн телефоны радио давтамжийн зурvasыг 2008 оны 12 дугаар сарын байдлаар нарийвчлан тоолж, өмчилгэй нь тогтоох, буртгэлд бүрэн хамруулж, тайлан тэнцээлд тусгах ажлыг 2009 оны 7 дугаар сарын 1-ний дотор шийдвэрлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар)-нд, дүнг нэгтгэн Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус даалгасугай.

8. Төрийн өмчийт болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшил газар болон баталгаажуулсан хэмжээг тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүр Төрийн өмчийн хороотой урьдчилан зөвшүүлжээг байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



9. Төрийн болон орон нутгийн өмчийн тооплогоор эд хөрөнгө дутагдуулсан хуулийн этгээдийн удирдлага, холбогдох ажилтанд хариуцлагын тооцох, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч, дунг Төрийн өмчийн хороонд хүргүүлжийг Төсвийн ерөнхийлөн захирагч наарт даалгасугай.

10. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай:

а) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урт хугацааны зээлийн ашиглалт, түүнийг төлсөн байдлын талаар судалгаа, дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тодорхой санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

б) тооплогоор дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх болон цаашид ашиглах боломжгүй болсон, хэрэгцээнээс илүүдэлтэй үндсэн хөрөнгийг шилжүүлэх, худалдах, данснаас хасах болон өмчийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг хууль тогтоомжийн дагуу холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авч, нэгдсэн дунг 2009 оны 2 дугаар сарын 10-ны дотор Засгийн газарт тайлгана;

в) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийтэй байгуулсан "Өмч зээлийн гэрээ"-г төрийн өмчийн эд хөрөнгийн зэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахад чиглүүлж, гэрээний заалтыг биелүүлэзгүй, өмч хөрөнгө дутагдуулсан, үргэдүүлсэн, бүртгэл тайланда тусгаагүй буруутай этгээдэд гэрээ болон зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлагын тооцоож ажиллах;

г) төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах захиалгат эд хөрөнгийг төвлөрүүлэн хангах асуудлаар санал боловсруулж 2009 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулах.

11. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэгт эрхлэх газрын дарга Б.Долгорт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 5-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
 хот

### Хөрөнгө оруулалтын гэрээний тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 29.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Оюутолгой, Тавантолгой ордыг ашиглах зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах яриа хэлэлцээ хийхийг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансух нарт даалгах нь:

2. Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансух нарт даалгах нь:

а) хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг байгуулж, байнгын удирдлагын хангаж ажиллуулсугай;

б) хөрөнгө оруулалтын гэрээний яриа хэлэлцээ хийхдээ Ашигт малтмалын тухай хууль, Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 40 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийт мөрдэж ажилласугай;

в) хөрөнгө оруулалтын гэрээ хийх хэлэлцээрийн явц, үр дүнг Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газарт 7 хоног тутамд танилцуулж байхын хамт гэрээний төслийг 2009 оны 1 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газрын хуралдаанд оруулсугай.

3. Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийх явцад санал өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий эрдэмтэн судлаачид болон төрийн бус байгууллагатай зөвлөлдөх хэсэг байгуулж ажиллуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
 хот

### Журам батлах тухай

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5, "Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн неөц хэлбэрээр байршуулах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 42 дугаар тогтооны үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсыг хөгжүүлэх санд неөц хэлбэрээр байршуулах хүнсний буудайг хадгалах байршил, түүнд байршуулах хүнсний буудайн хэмжээг тогтоох, худалдан авах, борлуулах, хадгалах үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хүнсний буудайг неөцлех байршил, түүнд байршуулах хүнсний буудайн хэмжээ"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Улсын Их Хурлын 2008 оны 42 дугаар тогтооюу зөвшөөрөгдсөн хөрөнгөд багтаан 100

мянган тонн хүнсний буудайг неөцлех ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт тус тус үүргэ болгосугай.

#### МОНГОЛ УЛСЫН

#### ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

#### САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

#### ХҮНС, ХӨДӨӨ АЖ

#### АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН

САЙД Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2008 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

### МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНД НЕӨЦ ХЭЛБЭРЭЭР БАЙРШУУЛАХ ХҮНСНИЙ БУУДАЙГ ХАДГАЛАХ БАЙРШИЛ, ТҮҮНД БАЙРШУУЛАХ ХҮНСНИЙ БУУДАЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ХУДАЛДАН АВАХ, БОРЛУУЛАХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсыг хөгжүүлэх санд неөц хэлбэрээр байршуулах хүнсний буудайг хадгалах байршил, түүнд байршуулах хүнсний буудайн хэмжээг тогтоох, худалдан авах, борлуулах, хадгалах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2. Неөц хэлбэрээр байршуулах хүнсний буудайн хэмжээг тогтоох, байршуулах, худалдан авах, борлуулах, хадгалах болон хяналт тавьж байгаа төрийн захиргааны төв байгууллага, ёмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, байгууллага, иргэн үйл ажиллагаандын энэхүү журмыг мөрдлөг болгоно.

3. Сангийн яам нь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн

неөц хэлбэрээр байршуулахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын бурангийн газартай неөцийн буудай хадгалалтын гэрээ байгуулна.

4. Стандартын шаардлага хангасан хүнсний буудайг Тариаланг дэмжих сан, улсын неөцийн агуулахад неөцлөн хадгална.

5. Хүнсний буудайг худалдан авах болон борлуулах үйл ажиллагааны зардлыг буудай худалдан авах үндэш шингээж, Монгол Улсыг хөгжүүлэх сангас зарцуулсан хөрөнгийг бурэн хэмжээгээр буцаан төвлөрүүлэх зарчим баримтална.

6. Хүнсний буудайг хүлээн авах, хадгалах, хяналт тавих үйл ажиллагаанд "Хүнсний буудай MNS-97-2004" болон холбогдох стандартыг дагаж мөрднө.

**Хоёр. Хүнсний буудайн нөөц бүрдүүлэх**

7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар нь Засгийн газраас тогтоосон хүнсний буудайн хэмжээг баримтлан Улсын Их Хурлаас баталсан хөрөнгийн дүнд багтаан газар тариалангийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс хүнсний буудайг худалдан авах, борлуулах, хадгалахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8. Хүнсний буудай худалдан авах гэрзээ, хүлээнхэлж ажилтуулж, тайлангийн маягтын загварыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд. Онцгой байдлын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын хамтарсан тушаалаар батална.

9. Хүнсний буудайн нөөц бүрдүүлэх, борлуулах, хадгалах үйл ажиллагааг Тариаланг дэмжих сан, улсын нөөцийн харьяа салбаргаар гүйцэтгүүлж зөвхөн хүнсний хэрэгцээнд зориулан гурилын үйлдвэрүүдэд жил бүрийн 2, 3 дугаар улиралд борлуулна.

10. Нөөцийн буудай борлуулсан үний Териин сан дахь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэн тухайн жилийн намрын ургацаас хүнсний буудайн нөөцийг дахин бүрдүүлэхэд ашиглана.

11. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар нь зах эзэл дэх гурилын хэрэгцээ, хангамжийг харгалзсан хүнсний буудайг борлуулах, тухайн жилийн ургацаас худалдан авч дахин нөөц бүрдүүлэх талаархи саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

12. Технологийн шаардлага хангасан агуулах бүхий аж ахуйн нэгжид хүнсний буудайг гэрээгээр хадгалуулж болно.

**Гурав. Хүнсний буудайн нөөцийн санхүүжилт**

13. Хүнсний буудайг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр агуулахад хүлээн авсны дараа Сангийн яам нь Териин санд байршуулсан Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс санхүүжилт хийнэ.

14. Хүнсний буудай нийлүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн улсын стандартын шаардлага хангасан хүнсний буудайг цэвэржингээр тооцсон тухай тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, гэрээ, тооцоо нийлсэн баримтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Онцгой байдлын ерөнхий газарт ируулно.

15. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Онцгой байдлын ерөнхий газар нь энххүү журмын 14-т заасан материалыг хянан уззээд санхүүжилт хийх хүснэгтийг Сангийн яаманд гаргана. Хүснэгтийд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нэр, худалдан авсан буудайн хэмжээ, унз, стандартын шаардлага хангасан тухай тодорхойлолт, гэрээ, тооцоо нийлсэн баримтын дугаар бичигдсэн байна.

16. Сангийн яам нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын хүснэгт, нэхэмжлэл болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан буудайн баримтыг үндэслэн мөнгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн данснаас Тариалан эрхэмлэлийг дэмжих сан, Онцгой байдлын ерөнхий газрын дансанд шилжүүлнэ.

17. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (Тариаланг дэмжих сан). Онцгой байдлын ерөнхий газар нь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн олгосон хөрөнгийг буудай нийлүүлсэн аж ахуйн нэгж, иргэн, хадгалач наарт гарзэний гүйцэтгэл, тооцоо нийлсэн баримтыг үндэслэн ажлын 5 едерт багтаан олгоно.

18. Нөөцийн буудайг шинжлэх, цэвэрлэх, агуулахад хүргэх зардлыг буудай нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хариуцна. Мен буудайг сэлгэх, хадгалахтай холбогдсон гарах зардлыг буудай худалдан авах үндэд оруулан тооцно.

**Дөрөв. Хяналт тавих**

19. Хүнсний буудай худалдан авах, борлуулах, хадгалах үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан териин захиргааны байгууллага болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар хулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж ажиллана.

20. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан териин захиргааны байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нөөцед авч байгаа хүнсний буудайн чанарт "Хүнсний буудай-MNS-97-2004" стандартын дагуу шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

21. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар нь еөрийн харьяа салбар, нэгжүүдэд худалдан авч байршуулсан нөөцийн буудай, зарцуулсан хөрөнгийн тайланг нэгтгэн хагас, бутэн жилээр Сангийн яаманд хүргүүлж энххүү журмын хэрэгжилтийн явцыг жил бүрийн 6, 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байна.



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №2 (575)

Засгийн газрын 2008 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ХҮНСНИЙ БУУДАЙГ НӨӨЦЛӨХ БАЙРШИЛ, ТҮҮНД БАЙРШУУЛАХ ХҮНСНИЙ БУУДАЙН ХЭМЖЭЭ

А. Онцгой байдлын өрөнхий газрын улсын нөөцийн салбаруудад худалдан авах хүнсний буудайн байршил, хэмжээ

№	Байршил	Тоо хэмжээ (мян.тн)
1	Булган аймаг, Сэлэнгэ сум	1.2
2	Булган аймаг, Хутаг-Өндөр сум	2.2
3	Дархан-Уул аймаг, Хонгор сум	3.2
4	Сэлэнгэ аймаг, Мандал сум	0.8
5	Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум	1.4
6	Төв аймаг, Жаргалант сум	1.0
7	Төв аймаг, Цээл сум	1.2
8	Увс аймаг, Баруунтуруун сум	0.2
9	Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум	0.6
10	Дархан-Уул аймаг, элеватор	22.2
Дүн		34.0

Б. Тариаланг дэмжих санд худалдан авах  
хүнсний буудайн байршил, тоо хэмжээ

№	Байршил	Тоо хэмжээ (мян.тн)
1	Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Хөтөл элеватор	24.0
2	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Сэлэнгэ элеватор	40.0
3	Өвөрхангай аймгийн Хархорин сум, Хархорин элеватор	2.0
Дүн		66.0

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
 хот

Засгийн газрын тохируулагч,  
хэрэгжүүлэгч агентлаг  
байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 5.1, 6.3-т заасны болон "Төрийн захирагзны байгууллагын тогтолцоо, бүтцийн

өрөнхий будүүчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг хавсралтын ёсоор байгуулан ажиллуулсугай.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд шинээр болон өвчлөн байгуулагдсант холбогдуулан Сэргээдэх эрчим хүчиний үндэсний төв, Эрчим хүчиний судалгаа, хөгжлийн төв, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Тээврийн үйлчилгээний төв, Авто замын хяналт, судалгааны төв, Усны хэмнэлтийн төв, Усны институт, Ой, усны хайгуул судалгааны төв, Банкны өр барагдуулах газар, Сорцын улсын хяналтын алба. Цем сургийн үржлийн төвийг тус тус татан буулгац, Сэргээдэх эрчим хүчиний үндэсний төв, Эрчим хүчиний судалгаа, хөгжлийн төв, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Тээврийн үйлчилгээний төв, Авто замын хяналт, судалгааны төв, Усны хэмнэлтийн төв, Усны институт, Ой, усны хайгуул судалгааны төвийн чиг үүргүүдийг шинээр байгуулагдсан холбогдох агентлагуудад. Банкны өр барагдуулах газрын чиг үүргүйг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт, Сорцын улсын хяналтын албаны чиг үүргүйг Стандартчилап, хэмжил зүйн газарт. Цем сургийн үржлийн төвийн чиг үүргүйг орон нутгийн захиргааны байгууллагад тус тус шилжүүлсугай.

4. Аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллаж, ўйл ажиллагааныхаа орлогоос санхүүжик байсан Засгийн газрын агентлагуудыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх зарчмыг шилжүүлэн, орлогыг улсын төсөөт бүрэн төвлөрүүлж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 198 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 270 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2004 оны

10 дугаар сарын 20-ны өдрийн 205 дугаар тогтоол, "Засгийн газрын агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 207 дугаар тогтоол, "Шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах газрыг байгуулах тухай" Засгийн газрын 2004 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 222 дугаар тогтоол, "Засгийн газрын агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 249 дүгээр тогтоол, "Усны хэрэг эрхлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 46 дугаар тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 48 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 201 дүгээр тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 263 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Усны үндэсний хороо болон Ой, усны хайгуул судалгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 263 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Усны үндэсний хороо болон Ой, усны хайгуул судалгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 4 дүгээр тогтоол, "Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны зохион байгуулалтын бүтэц, ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 202 дугаар тогтоол, "Түүш, эрчим хүчиний яамны зохион байгуулалтын бүтэц, ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 203 дугаар тогтоол, "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, ўйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 236 дугаар тогтоол, "Сэргээдэх эрчим хүчиний үндэсний төв байгуулах тухай" Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 160 дугаар тогтоол, "Төв байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 37 дугаар тогтоол, "Малын удмын сангийн үндэсний төв, цем сургийн үржлийн төв байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 172 дугаар тогтоолын 2, 3, 4 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН ЖАГСААЛТ

Эрхлэх асуудлын хүрээ, харьялал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хурзэнд	<ul style="list-style-type: none"> <li>-Тагнуулын ерөнхий газар</li> <li>-Үндэсний хөгжил, шинотгэлийн хороо</li> <li>-Цемийн энергийн газар</li> <li>-Төрийн өмчийн хороо</li> <li>-Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газар</li> </ul>	
Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын хурзэнд	<ul style="list-style-type: none"> <li>-Шударга өрсөлдөөн, хэрглэгчийн төлөө газар</li> <li>-Стандартчилал, хэмжил зүйн газар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Оюуны өмчийн газар</li> </ul>
Шадар сайдын Эрхлэх асуудлын хурзэнд	<ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн хяналтын өрөнхий газар</li> <li>-Онцгой байдлын ерөнхий газар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Хүүхдийн төлөө газар</li> </ul>
Монгол Улсын сайд. Засгийн газрын Хэргээ эрхлэх газрын дарьын эрхлэх асуудлын хурзэнд		<ul style="list-style-type: none"> <li>-Удирдлагын академи</li> <li>-Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар</li> </ul>
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хурзэнд		<ul style="list-style-type: none"> <li>-Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн Газар</li> <li>-Гадаадын хөрөнгө оруулалтын газар</li> </ul>
Сангийн сайдын Эрхлэх асуудлын хурзэнд		<ul style="list-style-type: none"> <li>-Гаалийн ерөнхий газар</li> <li>-Татварын ерөнхий газар</li> </ul>
Хууль зүй, дотоод хэргийн сайдын Эрхлэх асуудлын хурзэнд	<ul style="list-style-type: none"> <li>-Цагдаагийн ерөнхий газар</li> <li>-Хил хамгаалах ерөнхий газар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Архивын ерөнхий газар</li> <li>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар</li> <li>-Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар</li> </ul>



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Оингазар -Усны газар -Цаг уур, орчны шинжилгээний газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Зөвсэгт хүчиний жанжин штаб
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Соёл, урлагийн хороо
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Иргэний нисэхийн еренхий газар -Төмөр замын газар -Авто тээврийн газар -Авто замын газар -Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
Нийгмийн хамгаалал, хөдөлгөрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Нийгмийн даатгалын еренхий газар -Хөдөлгөр, хапалжийн үйлчилгээний газар
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Жижиг, дунд үйлдвэрийн газар -Мал эмнэлэг, уржлийн газар
Эрдэс баялаг, эрчим хүчиний сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Ашигт малтмалын газар -Газрын тосны газар -Эрчим хүчиний газар
Зруул мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Биеийн тамир, спортын газар -Эрүүл мэндийн газар

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12  
Төрийн ордон

262420  
Индекс: 14003

329487

Хэвлэлийн хуудас 2/5